

Торгон зам ба Хятан бунхны ханын зураг

Бай Баянтал^{1,*}

Товч агуулга: Хятан улс (907-1125) нь төр байгуулсан 200 гаруй жилийн хугацаанд өөрсдийн уламжлалт соёлын суурин дээр, Тан, Түрэг, Уйгур, Бохай, Алтан, Сүн зэрэг ойролцоо цагт оршиж байсан улс, үндэстний соёлын охь болсон содон зүйлсийг шингээн авч, улмаар хятан соёлоо баяжуулан хөгжүүлж, үндэстний өвөрмөц онцлогтой соёлыг бий болгосон байна. Ийнхүү хятан үндэстнээр голлосон соёл нь олон талын шинжээрээ тал нутгийн соёлын хөгжилд нэгэн оргил болохын хувьд Төв Азийн дундад эртний соёлын хөгжилд онцгой байр суурь эзэлдэг юм.

Түлхүүр үг: Торгон зам, Хятан, бунхны ханын зураг

Удиртгал

Монгол Улсын нутгаас Хятаны булш оршуулгын дурсгал илэрч олсон нь цөөн тул археологийн судалгаанд хятаны тэр дундаа язгууртны бунхант оршуулгын талаарх судалгааны материал хомс байдаг (Эрдэнэбат 2018). Харин Хятаны үндсэн нутаг БНХАУ-ын Өвөр Монголд энэ талын судалгаа өнгөрсөн зууны эхээс авахуулаад өнөөг хүртэл тасралтгүй хийгдсээр байгаа төдийгүй зарим талаар нэлээд амжилтанд хүрээд байгаа нь тэдний нийтлүүлж буй судалгааны бүтээлд тусгалаа олсон байна. Бунхант оршуулгын зан үйл нь Хан улсын үеэс эхтэй бөгөөд Тан улсын үе хүртэл уламжлан ирж, улмаар энэхүү соёл нь торгоны замын нөлөөгөөр дамжин хөрш зэргэлдээ нүүдэлчдийн төр улс болох Түрэг, Уйгур, Хятанд нэвтэрчээ. Тухайлбал, Төв Азид өргөн дэлгэрсэн байсны гэрч нь Монгол улсын Булган аймгийн Баяннуур сумын нутгаас илэрсэн Майхан уулын Шороон Бумбагар, Зүүн хойд Азийн бүс нутаг болох Өвөр Монгол, Солонгосын Когурёгийн ханын зурагт бунхнууд юм. Бунхант оршуулганд бусад булшны адил талийгаачийн эдлэж хэрэглэж байсан хувцас өмсгөл, гоёл чимэглэл, сав суулгын зүйлсийг дагалдуулан тавьдаг ч хамгийн сонирхолтой нь бунхны хананд баялаг агуулга бүхий өнгө ялган будсан зураг дүрсэлсэн явдал юм. Ханын зурагт талийгаачийн амьд сэрүүн байх үеийн зэрэг зиндаа, ямар үйл хэрэг эрхэлж байсан, нутаглаж байсан нутаг ус, ахуй амьдрал, ан ав, хувцас өмсгөл, хоол хүнс, тоглоом наадгай зэрэг олон зүйлийг дүрсэлсэн байдаг.

Эдгээрээс Хятаны оршуулгын соёлд өргөн тархаж, томоохон язгууртнуудын ихэнхийг нь ганц болон олон өрөөтэй бунханд оршуулах бөгөөд бунхны ханын

зурагт торгон замын харилцаа холбоог илтгэх үйл явдал бүхий цөөнгүй дүрслэл байх бөгөөд тэдгээрийг гээг үс, хувцас өмсгөл, зугаа цэнгэл, тоглоом, хоол хүнс хэмээн ангилан товч авч үзлээ.

Гээг үс, хувцас өмсгөл. Үсний засал бол түүх, соёлын нэгэн үзэгдэл юм. Ээдрээтэй түүхэн хөгжлийн явцад үндэстэн бүрийн үсний засал нь нэг талаар өвөг дээдсээс уламжлан авсан зан заншлын дагуу ирсэн зүйл тул тухайн ард түмний соёлын онцлог болдог. Нөгөө талаар гадны соёлын нөлөө шаардлагыг хүлээн авсны улмаас бий болсон тул өөрчлөн хувиргах боломжгүй байдаг. Иймээс энэ нь түүхэн хөгжлийн онцлогийг тусган харуулах нэгэн хэрэгсэл болдог. Хятанчуудын мянга гаруй жилийн түүхэн хөгжлийн явцад үсний заслын хэлбэр маяг нь хэзээд хувиршгүй нэгэн хэвийн байсангүй. Гэхдээ хятаны соёлын онцлогийг удаан хугацааны туршид хадгалан үлдээсэн нэгэн зүйл нь эр эм, хөгшин залуу ялгалгүй бүгд үсээ хусдаг байжээ. Үүгээрээ тэд төв хятадын заншлаас тод ялгардаг.

Төв Хятадын хүмүүсийн уламжлалт ойлголтоор бол хүний бие махбод, үс арьсыг аав ээжээс өвлөж авсан тул түүнийг амар хялбараар өөрчлөн засаж янзалж үл болно. Тийм учраас үс тавих явдал наандаж Жоу, Цин улсын үеэс эхлэн эртний хятадын ард түмний уламжлалт зан үйл болж хөгжсөн байна. Үс тавих хэлбэр нь ерөнхийдөө 2 үндсэн төрөл байна. Нэгд нь үсийг сүлжин толгой дээрээ шуун шанхлах, хоёр дахь нь үсийг багцлан боох зэрэг болно. Эрэгтэй хүн насанд хүрээд малгайн титэм өмсдөг. Энэ тухай “Shiming” хэмээх толь бичигт: “冠, 贯也。所以贯韬发也” буюу хэргэм зэрэг ахиж, титэм малгай өмсөх учир гээг үсээ засч, янзлах ёстой” хэмээн тэмдэглэжээ (Тян гуан лин 1995: 38).

Хятан нарын үсээ хусах зан үйл нь Сяньби нараас уламжлалтай бөгөөд үс хусах янз бүрийн хэлбэрүүд нь урт удаан түүхэн хөгжлийн явцад үүсэн бий болсон өөрчлөлтүүд юм. Одоогоор бидэнд мэдэгдэж буй хэрэглэгдхүүнээс харахад үсээ хуссан баримтууд нь

¹ БНХАУ, ӨМӨЗО, Хөлөнбуйр дээд сургууль

* Холбоо барих зохиогч: baibayintala@163.com



Зураг 1. Тан, Уйгур, Хятан бунхны ханын зурагт эзнээ хүлээж буй агтчинг тус тусын онцлогтойгоор дүрсэлсэн нь

Хятаны үеийн хятан нарт байна. Эдгээр гээг үсний засалтын хэлбэрүүд нь Сяньби болон Баруун Жоугийн үс хусах аргаас өөр болох нь тодорхой байна. Улс байгуулахаас өмнөх 500 жилийн хооронд хятан нарын үс хусах хэлбэрийг харин мэдэх боломжгүй байна.

1. Толгойн оройн хэсгийн үсийг авч, бусад хэсгийг хайчлан богиносгоно. Толгойн 2 талд урт ус үлдээн тавьж чихний хажуугаар унжуулна. Энэ төрлийн үсний хэлбэр Чинлин онгон, Зүүн Баарин хошууны Фүшанди тосгоны Си хятан бунхны зураг болон үс дамжин хадгалагдаж ирсэн Елюй бэйгийн “Нумтай морьтны зураг” зэрэгт дүрслэгдсэн байна (Зураг 5.3).

2. Чамархайн хэсэгт урт үс үлдээх эсвэл гэзгийг сүлжих, задгай тавина. Бусад хэсгийн үсийг хайчлан авах эсвэл хусаж авдаг байжээ (Зураг 5.4).

3. Чихний ар талын хэсэгт урт үс үлдээж бусад хэсгийн бүх үсийг хусаж авна. Энэ төрлийн үсний хэлбэр Хугуй-гийн зурсан “卓歇图” хэмээх зурагт бий (Зураг 5.5).

4. Духны хэсэгт хоёр урт туг үсийг үлдээж, зулай хэсгийн үсийг тайран авснаар гурвалжин хэлбэрийн сэтэрхий хэсэг бий болно. Үлдээсэн үсийг шулуун гээг юмуу гөрж сүлжин чихний хэсгээр унжуулж бусад хэсгийн үсийг хусаж авна (Зураг 5.6).

5. Духны гол хэсгийн үсийг тайрч богиносгох ба 2 үзүүр хэсгийг уртаар үлдээж чихний хэсгээр унжуулна. Бусад хэсгийн үсийг хусна (Зураг 5.7).

6. Хоёр санчигны үсийг уртаар нь үлдээж хацарны

хэсгээр унжуулах ба бусад хэсгийн үсийг хайчлан богино болгоно (Зураг 5.8).

7. Дух болон санчигны хэсэгт урт үс үлдээн бусад хэсгийн үсийг хусаж авна (Зураг 5.9).


Дээр дурдсан гээг үсний засалтын 7 хэлбэрүүд нь үндсэндээ хятан эрчүүдийн хоёр гөхөл үс тавих үндсэн заслын доторх янз бүрийн өөрчлөлтүүдийг харуулж байна. Энэхүү үс заслын хэлбэр нь хөрш зэргэлдээ нүүдэлчин аймаг, улсад соёлын солилцоогоор нэвтэрч нөлөөлсөн тал бий.

Хувцас өмсгөлийн тухай. Хятан улс байгуулагдахаас өмнө болон хятаны эхэн үеэр хятанчууд голдуу ан гөрөө хийгээд таван хошуу малынхаа арьс үслэг, ноос ноолуурыг боловсруулан хувцас хийж өмсөж байжээ. Гэтэл археологийн судалгаагаар илэрсэн олдворууд ба Хятан улсын бунхны ханын зураг, Елюй Бей, Ху Гүй мэтийн хятан зураачдын уран зурагт илэрсэн хятанчуудын хувцас өмсгөлийг үзэхэд нэлээд боловсон шатанд дэвшин орсон байна.


Хятанчуудын хувцас өмсгөлийн соёлын эргэлт, хөгжилтийн тухай “Хятан улсын судар”-т өгүүлэхдээ: “Тайцзу хаан Елюй Абаожигийн авга Шулан үгэ ноён сууж байх үедээ Шар мөрний өнтэй шимт нутгийг эзэлж эхлэн хот суурин байгуулж, ялам, олс тарих аргыг нэвтрүүлж, нэхэж сүлжих үйлийг сургасан” хэмээн тэмдэглэжээ. Тэнд бас, “Тайцзу хааны умар зүгт хаан сууж, Тайцзун хаан Дундад орныг эрхшээгээд бор



Зураг 2. Тан улсын үеийн бунхны ханын зурагт дүрсэлсэн бар



Зураг 3. Булган аймгийн Баяннуур сумын Майхан толгойн бунхан. Уйгурын үеийн бунхны ханын зурагт дүрсэлсэн бар




Зураг 4. Хятаны үеийн Долоон айл тосгоны 1-р бунхны хананд дүрсэлсэн барын дүрслэл

цагаан булганы арьс, торго дурданг сав сав, боодол боодлоор тээж авчрав. Нарийн гоё зөөлөн ноолуураар нутагтаа бүдүүлэг торгомсог нэхвэй. Дээл малгайн дүрмийг тогтоож, хойд хорооны жишээ улсын хувцас өмсөж, өмнө хорооны жишээ хятад хувцас өмсөж тус тусын ялгамд тохируулвай. Улсын хувцсыг нарийнаа тодорхойлж, эл ордоноо эхлэн өмсүүлвэй” гэж бичсэн байна (Ляо улсын судар, 56-р боть 153).

Нангиад сурвалжид өгүүлж байгаа, Хятан улсын хувцас гэдэг нь хэрэг дээрээ төрийн ёслол ба тахил тайлгад өмсөх хаад язгууртан, ихэс сайдын хувцсыг хэлж байна. Хятан улсын хувцасны хуулиар төрийн албанд өмсөх, ерийн цагт өмсөх, ав хоморгонд өмсөх, бэлэвсрэл гашуудалд өмсөх дээл хувцас гэж ялган үүнийгээ дотор нь хаад язгууртны өмсөх, сайд түшмэдийн өмсөх гэх мэтээр нарийн зааж өгсөн байдаг. Хятан гүрний нангиад хувцас нь мөн энэ мэт дэс ялгамжаатай, их төлөв Тан улс болон Таван төрийн Хожуу Жинь улсын хэвшлийг журамлаж зэрэг дэсийн талаар нэн нарийн ялгаатай болгосон байжээ.

Хятан үндэстний уламжлалт хувцасны соёл нь Хятан гүрний хаад язгууртан сайд түшмэдийн төр ёслолын хувцас өмсгөлийн суурь болно. Энэ суурин дээрээ хятанчуудын төр тогтнохын дагуу тухайн нийгэм түүхийн хөгжлийн онцлогийг тусгасан шинэ нэг зүйлийн үндэстний хувцсыг буй болгожээ. Энэ нь хаад язгууртан, сайд түшмэдийн байр суурь, эрх сүрийг товойлгосноор нийгмийн анги давхаргын ялгарлыг харуулсан бэлгэ тэмдэг болсон байна.

“Хятан улсын судар”-т Хятан хаад язгууртны төрийн хувцасны үүсэл хийгээд хөгжил хувирлын тухай: “Тайцзу хаан улаан барс жил хаан ор суужээ. Төрийн хувцсанд хуяг өмсөж гэнэн явдал гарахыг сэрэмжилвэй. Түүнээс Зи Зигийн ёслол, од харвахуйд цөм ийм хувцас өмсдөг бөлгөө. Шэн-цзун хааны



Зураг 5. 1,2-Улаанхадын Нингчэн сианы Наншиангэний булинаас олдсон хүний дүрт олдворын үсний хэлбэр, 3-16. Насанд хүрсэн эрэгтэй хүний үсний хэлбэр

Тун-хэгийн тэргүүн онд Чэнь-тянь Хуанг Тайхуг өргөмжлөхүйд гутгаар дэсээс дээш хэргэмтэн хятад төрийн хувцас өмсөж гутгаар дэсээс доргош хэргэмтэн от харвахуйд өмсдөг хувцсыг өмсөх болвой. Хаан чэрбигийн луут малгай өмсөж, ороомолтой улаан дээл өмсөн, хас хавтсан чимэгт хирсийн арьсан бүс бүсэлж, ороомолтой гоё гутал өмсөмүй. Үүнийг улсын хувцас луут титэм хэмээмүй. Тайцзун хаан хэмэрлиг дээл, алтан бүс болгон хувируулвай. Сайд түшмэд эсгий малгай өмсөөд алтан цэцгээр чимэх буюу сувд, шувууны өдөөр чимж, магнайнаас урагш алтан цэцэг унжуулан, нэгэн давхар уут нэхэж дотор нь нэг бут гээг хиймой. Эсхүл Эү Ша Моу малгай мэт ша малгай өмсөмүй. Гэвч саравч үгүй. Чихийг дарахгүй. Магнайн өмнө алтан цэцэг сүлбэж, дээр нь хүрэн бүч зангидаж үзүүрт нь сувд хэлхэмүй. Хувцас нь хүрэн үйтэн дээл, дээгүүр нь арьсан бүс бүсэлж, бүснийхээ дээгүүр шар улаан нарийн сураар сүлжин ороож алт, хас, болор, номинг хадаж чимээд “фэнзи” гэж хэлмүй. Тайцзун хаан өөрчилж хэмэрлиг дээл, алтан бүс болговой. Хуэй-тунгийн тэргүүн оноо олон сайд нарын насан ахиж хэргэмтэй бүгдэд шагнавай (Ляо улсын судар 1974: 1446) гэхчлэн өгүүлжээ.

Үүнээс үзвэл хятанчуудад угтаа төрийн хувцас



Зураг 6. Улаанхадын Уухан хошууны Пи жсян гоу бунхны зураг. Морин бөмбөг тоглож буй нь

хэмээн байсангүй ажээ. Елюй Абаожигийн үед хуяг дуулга, байлдааны хувцсаар хаан төрийн хувцас болгож байсан бол Хятан улсын хоёрдугаар хаан Елюй Дэгуаны үеэс Хятадын төрийн хувцсыг дүрэмлэн Хятан төрийн хувцсыг үүдсэн ажээ. Түүнчлэн үүнээ удаа дараагаар өөрчилж байсан юм байна. Гэвч хувцасны хэлбэр нь үндсэндээ хятанчуудын уламжлалт хувцасны хэв янзыг хадгалжээ.

Хятанчуудын шинээр үүдсэн хувцсанд бас албаны хувцас гэж байдаг. Хятанчууд төр байгуулахаасаа өмнө аймаг аймгийнхаа уламжлалт хувцсыг өмсөөд л аймгийн холбооныхоо хэрэг учирт оролцож байжээ. Төр байгуулсны дараа төрийн тушаалтан ба төрийн байгууллага яаманд ажиллагсдад тусгай албаны хувцастай болсон байна. “Хятан улсын судар”-т тэмдэглэснээр: “Албаны хувцсыг “жанггүве” хэмээмүй. Бор өнгийн эдээр хийнэ. Син-цзун хааны Чжун-сигийн 22-р онд зарлиг буулган найман үүдний хийг алчуур ороолгох болговой. Дао-цзун хааны Цин-нингийн тэргүүн онд зарлиг буулган гавьяат төрлийн хүүхэд ач нар болон иркин, дэд түшмэл болон зарлигт явагч тушаалтан алчуур ороохгүй хэмээн тогтовой. Хаан хүрэн алчуур ороож, бор үйтэн дээл өмсөн хас бүс бүслэх буюу улаан цэгдэг өмсөмүй.



Зураг 7. Хэбэй мужийн Сюань хуа-гийн хятан хүний бунханд найрал хөгжмийг дүрсэлсэн нь

Сайд түшмэд бас алчуур ороож бор дээл өмсөмүй” гэж тэмдэглэжээ (Ляо улсын судар 1974: 1450).

Хятанчуудын хаад язгууртан ба сайд түшмэдийн өмсдөг энгийн хувцас гэж буй. Түүнийг хятадаар “фанггүюй” гэж хэлжээ. Зүүн монголчуудын хөвөнтэй тэрлэгийг “фангху” гэж хэлдэг нь үүнээс ирсэн бололтой. Энгийн хувцас нь голдуу: “ногоон цэцэгтэй уйтан хувцас, дотор хувцас нь улаан ногоон өнгөтэй. Эрхэм ихэс булган дах нөмөрч, хар хүрэн өнгөтэйг нь эрхэмд үзэж хөх өнгөтэйг нь дээдэд үзмүй. Бас цагаан хэрэмний арьсан дах буй. Тэр нь маш цав цагаан байдаг. Доордос нь тарвага, хонь, усан хулгана, хярсны арьсан дах өмсөмүй” (Ляо улсын судар 1974: 1454).



Зураг 8. Уухан хошууны Ямаат уулын 1-р бунхан. Эзэн хоол идэж, архи ууж байгааг дүрсэлсэн нь



Зураг 9. Торгоны замаар дамжин ирсэн тоть шувуу, азарган тахиануудыг зодолдуулан зугаацаж байсан нь

Зугаа цэнгэл, тоглоом. Хятан язгууртнууд бусдын адил найр наадам, зугаа цэнгэлд дуртай байжээ. Ханын зурагт дууч хөгжимчдийн хамт бунхны эзэн морь, нохойтойгоо хамт байж баясан цэнгэж байгаа амьдарлыг зураглажээ. Эрэгтэй эмэгтэй хөгжимчин ба бүжигчин охид байж, хөгжимчин нь бишгүүр үлээж товшуур тоглож бүжигчин нь эргэлдэн бүжиглэж буй дүрслэлтэй (Зураг 7). Ан ав, дуу хөгжим, архи дарснаас гадна ноёд баячууд нь хаа холын халуун орноос үнэтэй тоть шувуу (Зураг 9) авчруулж тэжээх, азарган тахиануудыг (Зураг 9) хооронд нь зодолдуулж, бооцоо тавих зэргээр зугаацаж байсныг зургаас харж болно.

Амьдрал ахуйд явж сууж байх зурагт бунхны эзнийг өдөр тутмын амьдрлын үзэгдлийг харуулсан байдаг. Хаалганы өмнө эрэгтэй зарц ба боол шивэгчин асран сувилж, гэр дотор нь шивэгчин охин асран үйлчилж тэвш өргөн толины хайрцаг барьж, толь өргөн сав суулга барих ба хувцас хунар тэгшилж гэр дотор ширээ, сандал, хувцасны авдар тавьсан байж, хувцасны өлгүүр дээр нь гэрийн эзний хувцас хунарыг өлгөсөн байдаг. Ан авын зурагт нь хятанчуудын ан авын амьдралын зан заншлыг илтгэж ан анд гарахад бэлтгэж байгаа байдал, ан гөрөөс тууж байгаа буюу харван намнаж байгаа байдал зэрэг бий. Морь унаж бөмбөг тоглож буй зураг нь Уухан хошуунаас малтаж гаргасан Хятан улсын бунхны ханын зураг дотор одоо байгаа хоёр хэсэг ханын зураг ба нэг хэсэг модон барын зураг байдаг. Зурагт дүрсэлснээр хятанчууд морь унаж бөмбөг тоглож байгаа байдлыг харуулсан нь хятанчуудын уламжлалт биеийн тамирын тэмцээн болох ба цэргийн сургуулилтын нэг хэлбэр болно. Энэ тоглоомонд язгууртнуудаас эхлээд харц ард хүртэл оролцож тоглодог нь уг тоглоом олон нийтийн дунд хүчтэй дэлгэрч тархсан спорт гэдгийг харуулж байна. Морин бөмбөгийг анхны дүрсэлсэн байдал нь Тан улсын Чинлин бунхны ханы зурагт дүрслэгдсэн байдаг бөгөөд тухайн үед нүүдэлчид болон суурин

иргэдийн соёл хамгийн ихээр хоорондоо холилдож байсан үе учир Тан улсын харьяанд байсан нүүдэлчин иргэд зааж өгсөн байхыг үгүйсгэхгүй юм (Жу Вэнь же 1971: 85) (Зураг 6).

Хоол хүнс, идээ ундаа. Сурвалжийн тэмдэглэл ба археологийн судалгаанаас үзвэл хятанчуудын идээ ундааны соёлыг улаан идээний соёл, цагаан идээний соёл, үр тарианы хүнсний соёл, жимс ногооны соёл гэж нарийвчлан авч үзэж болно. Хятанчуудын идээ ундааны соёлыг хөгжлийн талаас нь ажиглаж үзвэл уламжлалт идээ ундааны соёл Түрэг, Уйгур зэрэг баруун хязгаарын үндэстнүүдийн идээ ундааны соёлын нөлөө ба хятадын Тан, Сүн улсын идээ ундааны соёлын нөлөөгөөр шинээр бүрэлдэн тогтсон идээ ундааны соёл гэсэн хоёр хэсэгт авч үзэж болно. Хятанчуудын уламжлалт идээ ундааны соёл: өмнөх судлаачид хятанчуудын идээ ундааны соёлыг дурдаснаар мах сүү цагаан идээ гэх мэтийн улаан цагаан идээг дурддаг. Үнэндээ тийм биш бололтой. Хятанчууд сүү цагаа, махаар гол болгодог мөртлөө монгол амуу, гурвалжин будааг хоол хүнс болгож байсан бөгөөд хээрийн жимс ногоог түүж идэж байжээ. Уухан хошууны Ян шаны 1-р бунхны ханын зурагт хятанчуудын архи цэгээ ууж байгааг харж болно. Хятанчуудын уламжлалт идээ ундааны соёлд улаан идээ гол болдог.

Хятан улсын сударт, “их говийн завсар хахир хүйтэн салхи шуурга их, тэжээвэр мал, ан гөрөө, загасаар хоол хүнс болгоно. Арьсыг өмсөж улирлыг дагана нүүдэллэж тэрэг мориор орон сууцаа болгомуй” (Temgetu 1984: 279). Үүнээс үзвэл, хятанчууд таван хошуу малаас гадна уул хээрийн ан гөрөө, ус мөрний загас жараахай идэж байжээ. Хятанчуудын мах чанаж байгаа зураг Баарин Зүүн хошууны Баян овооны Хятан улсын ханын зурагтай бунханд илэрсэн байна. Тус зурагт нэг эрэгтэй сөгдөж суугаад гартаа төмөр сэрээ барьж өндөр дөрвөн хөлтэй том тогоонд буцалгаж байгаа махыг сэрээгээр эргүүлж байгаагаар дүрсэлсэн



Зураг 10. Ханын зурагт хятан хүмүүс хоол хүнсийг хэрхэн хийж байгааг дүрсэлсэн нь

байдаг (Улаанхад...1999: 12). Уухан хошууны Ямаат уулын бунхны ханын зурагт мах чанаж байгаа зураг бас бий. Тус зурагт дөрвөн хөлтэй нэг том тогоо, гурван жижиг тогоо тулж том тогоонд нь гурван хонины мөч чанаж байгаа бөгөөд нэгэн хятан эр амандаа хутга зууж, ханцуйгаа шууж, махыг чанаж байгаагаар зурсан байна. Нөгөө хятан залуу тогооны өмнө сууж хуурай түлээг хугалж гал түлж байгаагаар дүрсэлсэн болно (Улаанхад ...1999: 15). Хятанчууд махыг чанаж идэхээс гадна бас борцлон хатааж идэж байжээ. Жишээлбэл, Умард Сүн улсад хүргэж байсан бэлгийн дотор үхэр, хонь, зэрлэг гахай, загас, бугын хатаасан мах үүнийг гэрчилдэг болно (Хятан улсын товчоон 750).

Улаанхадын Баарин Зүүн хошууны Цагаанхад сумын Ди Шүи и (dishui yi 滴水壹)-н бунхны ханын зурагт хоол хүргэж буй зураг байдаг. Түүнд хоёр зарц нэг том цар тавганд хоёр таваг мантуу, хоёр таваг бууз, нэг таваг боорцог, нэг таваг жигнэсэн банш, нэг таваг чанасан өндөг аваад явж буй (Лин хуаны түүхийн тэмдэглэл 2005: 201) зураг болно. Хятанчуудын идээ ундааны соёлоо өргөжүүлж чадсаныг тэдний амьдралын түвшин дээшилснийг илтгэхээс гадна соёл иргэншлийн хэр түвшинд хөгжсөнийг харуулж байна. Хятанчууд идээ ундааны соёл хөгжих нь зөвхөн хятадын амуу будааны соёл дээр хөгжсөн биш Дундад Азийн Түрэг, Уйгур улсаас амуу тариа, гуа жимсийг оруулж ирэх болжээ.

Уйгураас буурцаг оруулж ирснээс гадна бас өөр төрлийн жимс тарвасыг (арвас) оруулан авч тарьж байжээ. Таван төрийн шинэ сударт тэмдэглэснээр

хятанчууд, уйгурыг дайлан дагуулаад түүний үр арвасыг олжухуй, вааран саван дотор үхрийн баасаар бүтээж тарьмуй, том нь хятадын дунгуа лугаа адил амт нь чихэрлэг ажээ (Таван төрийн шинэ судар. 73-р боть 512).

Баруун хязгаарын ард түмэн жимс их тарьдаг тэндээс тарвас, тоор, алим, анар зэрэг жимсний олон төрлүүд хятанчуудын нутагт торгоны замын арилжаа наймаагаар нэвтэрч зарим үед хятад оронд дамжуулах гол өртөө болжээ. Эдгээр жимсийг хятанчууд хятадаас өмнө тарьж идэж байжээ (Пэрлээ 2008: 110-111). Хятан улсын сударт тэмдэглэсэн хаад, ноёд Жоу сян (州zhou, 县xian)-ны хүрээлэнд тарьдаг жимснүүд нь эдгээр жимснүүд болно. Сурвалж бичигт тэмдэглэгдсэн хятанчуудын идэж хэрэглэж байсан эдгээр жимс жимсгэнийг батлах баттай археологийн баримт ханын зурагт дүрслэгдэн үлдсэн нь буй. Уухан



Зураг 11. Ханын зурагт жимс таваглаж тавьсан байдал

хошууны Ямаат уулын 1-р бунхны зүүн ханан дээр бунхны эзний хуримлан найрлан цэнгэж байгаа зурагт нийт дөрвөн эрэгтэй хүнийг зуржээ. Үүнд бунхны эзэн нь сандал дээр сууж баруун гараа сандалны түшлэг дээр тавьж баруун тийш хазайсан байдалтай суусан байна. Түүний ард дугуй заамтай урт тэрлэг өмсөж дундуураа суран бүс бүслэн толгойдоо хятан гэзэг тавьсан богино сахалтай хүн хоёр гараараа нэг таваг барьж зогссон байна. Бунхны эзний өмнө эсгий малгайтай, дугуй захтай урт дээл өмсөж арьсан бүс бүсэлсэн богино сахалтай эрэгтэй хүн бие нь бөхийж тавган дээр зургаан талтай хундага тавьж эзэндээ өгч байгаагаар зуржээ. Түүний ард нэгэн богино сахалтай эрэгтэй хүн дугуй захтай дээл өмсөн арьсан бүс бүсэлж, нэг тавагт бага амсартай, амсрыг тагаар тагласан тавгыг хоёр гараараа барьж байгаагаар зуржээ. Бунхны эзний өмнө нь нэгэн дөрвөлжин ширээн дээр өргөн ирмэгтэй том таваг тавьж гурван тарвас тавьж нөгөө таваг дотор анар, тоор, чавга мэтийн жимсийг тавьснаар зуржээ (Зураг 11) (Сүн Жян хуа 2009: 165).

Дүгнэлт

Хятан бунхны ханын зургийн зохиомж нь ямар ч хийсвэрлэл, уран сайхны хэтрүүлэггүй зөвхөн талийгаачийн түүх намтартай холбогдох үнэн бодит үйл явдлыг дүрслэх гол утга учиртай. Тухайлбал, Улаанхад хотын Уухан хошууны Ямаат уулын бунхны ханын зурагт нурамтай гал дээр зэс данханд цай чанаж буй зураг байдаг. Энэ нь бунхны ханын зураг дахь найрын ширээ базааж байгаа хэсэгт архины ширээний өмнө тавиур дээр хар архи зэрэгцүүлэн тавиад түүний хажуу шалан дээр нэг чулуун бутан цэгээ тавьсан байх ба бутны дотор билүүрийн иш нь харагдаж байна. Үүнээс гадна будаанаас, цэгээнээс архи нэрэх уламжлалтай байжээ.

Хятан бунхны ханын зургийг нийтэд нь ажиглавал хятанчууд нүүдлийн соёлыг суурьшмал соёлтой уялдуулж уламжлалт зан заншил, соёлыг, шинээр бий болсон соёлтой хамтад нь хөгжүүлж байжээ. Бидний хувьд хятан бунхны ханын зураг нь археологийн биет эд өлгийн зүйлсийн нэгэн адил судалгааны өндөр ач холбогдолтой, олон талын мэдээлэл агуулсан түүхэн сурвалж болохыг жишээ, баримтаар онцлон тэмдэглэж байна. Эдгээр нь торгон замын сүлжээгээр, соёлын солилцоогоор харилцан нэвтэрч байсныг тод томруун харуулж байна.

Abstract

Silk road and Khitan tomb murals

Bai Bayintala

During the more than 200 years since the establishment of the state, the Khitan empire (907-1125) has absorbed the unique elements of the cultures of the countries and nations that existed at the same time, such as the Tang, Turkic, Uyghur, Bohai, Jurchen Jin and Chinese Song dynasties, on the basis of its own traditional culture, and thus enriched and developed its own Khitan culture, creating a unique culture of the nation. Thus, the culture centered on the Khitan nation occupies a special place in the development of ancient culture in Central Asia, as a peak in the development of steppe culture with its many aspects.

Keywords: Shinekheen buriyad, Serge bosgoqu, Chinggis khan's autumn patch

Ном зүй

Пэрлэй, Бо. (2008). Хянгана даваа дагуу нүүдлийн соёл иргэншил. – “Хятанчуудын эдийн соёл”. Цуврал IV. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. Хөх хот.

Тэмгэгү (1984). Хятан улсын эх адгийн хэргийг тэмдэглэсэн шастир. Хөх хот.

Эрдэнэбат, У. (2018). Хятан нар ба Ляо гүрэн. – “Монголчууд: Талын нүүдэлчдийн уламжлал (Нэн эртнээс XII зууны эхэн)”. Монсудар, УБ: 180-215.

曹建华: 《临潢史记》内蒙古人民出版社1999年. Лин хуаны түүхийн тэмдэглэл (1999). Хөх хот.

脱脱: 《辽史, 卷五十六, 仪卫志二, 国服》, 中华书局1974年. Ляо улсын судар, 56-р боть, ёслол хамгаалалтын тэмдэглэл 2, улсын хувцас.

脱脱等: 《辽史》中华书局1974年, Ляо улсын судар (1974). Бээжин.

叶隆礼: 《契丹国志》, 上海古籍出版社, 1985年. Хятан улсын товчоон, Тэргүүн боть,

欧阳修: 《新五代史, 卷七十三, 四夷附录第二》, 中华书局1974年. Таван төрийн шинэ судар, 73-р боть, Бээжин, 2014.

敖汉旗四家子北羊山1-3辽墓发掘简报, 《内蒙古文物考古》内蒙古人民出版社, 1999年. Улаанхад. (1999). Улаанхад хотын Уухан хошууны Ямаат уулын 1, 3-р бунхныг малтсан товч түүх. Өвөр Монголын хууч судлал ба түүхийн дурсгалт зүйл сэтгүүл. Хөх хот.

朱文杰: 唐墓壁画《打马球图》, 陕西省乾县唐章怀出版社, 1971年. Жу Вэнь же (1971). Морин бөмбөг тоглож буй зураг. - Тан улсын ханын зураг. Бээжин.

孙建华: 《内蒙古`辽代壁画》, 北京文物出版社2009年. Сүн Жян хуа (2009). Өвөр Монголын

Хятаны үеийн ханын зураг. Бээжингийн түүхийн дурсгалт зүйлийн хэвлэлийн хороо. Бээжин.

田广林:《契丹礼俗考论》, 哈尔滨出版社, 1995年。Тян гуан лин (1995). Хятаны ёс заншлын шинжлэл. Харбины хэвлэлийн хороо.

乌力吉:《辽代墓葬艺术中的捺钵文化研究》 北京文化艺术出版社 2013年。Өлзий (2013). Хятан улсын бунхант оршуулгын урлагийн дундах нүүдэлчин соёлын судалгаа. Бээжин.

Received: Oct. 7, 2024; Revised: Nov. 5, 2024; Accepted: Dec. 16, 2024

